



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/326

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар (Улсын хэмжээнд)- Цаг уурын өртөөний барилгын шинэчлэл (Булган, Сэлэнгэ, Ингэт толгой) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөнбулаг” ХХК-тай 251,772,123 (хоёр зуун тавин нэгэн сая долоон зуун далан хоёр мянга нэг зуун хорин гурав) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөнбулаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (С.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.


4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

05 дугаар сарын 11-ны өдрийн А/З/26 дугаар захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	4 371 803	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	4 371 803	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2 185 901	Ү.Бямбасүрэн
4	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
5	Баталгаат хугацаа	3 жил	Б.Ууганбаяр
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн